

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**
(2022 оны жилийн эцсийн байдлаар)

2022.12.27

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дун, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах зорилготой.

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд хүрсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг удирдлага болгов.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 2 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний засаглалын бодлого бүлэгт тусгагдсан зорилт, арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт, хүрэх түвшингийн үр дунд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ **“Тодорхой үр дунд хүрсэн” буюу 95.0 хувьтай** байна.

ТӨБЗГ нь хариуцан хэрэгжүүлэх 1 арга хэмжээ (МУТЖҮЧ - 5.1.1, ЗГУАХ – 4.4.10, МУЖХТ – 4.1.19), 1 арга хэмжээ (МУТЖҮЧ – 5.1.1, ЗГУАХ – 4.4.10, МУЖХТ - 4.4.1.)-ний хамтран хэрэгжүүлэгч (ХЗДХЯ) байгууллагаар үүрэг хүлээсэн.

4.1.19. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг дараах байдлаар төлөвлөсөн. **Үр дун – 90.0 хувь:**

- **Хууль батлагдсан байна:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах бусад хуулийн төслийн хамт УИХ-ын 2022 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрийн чуулгангаар уг хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг хэлэлцээд Үзэл баримтлалын хүрээнд дэмжин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн Байнгын хороонд шилжүүлсэн;
- Төрийн болон орон нутгийн өмчийт компанийн тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх Эдийн засгийн Байнгын хорооны дэргэд байгуулагдсан ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөлтэй хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Б.Энхбаярын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу гишүүд тодорхой чиглэлээр ажилласан;
- **3 журмын төслийг баталж мөрдүүлсэн байна:** Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн “Төрийн өмчийт болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын захиралтай онцгой нөхцөл бүхий

хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор;

- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажилд ашиглагдах аргачлал маягтыг ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор;
- Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн ТӨБЗГ-ын 2022.02.22-ны өдрийн 65 дугаар тогтоолоој тус тус батлуулан мөрдүүлж байна.
- Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам"-ын төслийг ЗГХЭГ-т, Автомашины дуудлагын үйлчилгээний тариф, зардлын норм, нормативд тусгах саналыг Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.
- **Компанийн засаглалын дундаж үнэлгээ 65-70 хувьд хүрсэн байна:** Компанийн засаглалын сайн туршлагыг судлах хүрээнд Сингапурын Темасек холдинг, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дэргэдэх Төрийн өмчийн зохицуулах хороотой холбоо тогтоох, хамтран ажиллах чиглэлээр ажиллав. БНХАУ-ын төрийн өмчит компаниудын нэгдсэн удирдлага, компанийн засаглалын асуудлыг тусгайлан судлах, холбогдох дүгнэлт, саналыг боловсруулсан;
- Төрийн өмчит 9 компанид хийсэн компанийн засаглалын 2022 оны үнэлгээ дунджаар 69.0 хувь байна.

4.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих арга хэмжээний хүрээнд зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтийг дараах байдлаар төлөвлөсөн. **Үр дүн – 100.0 хувь:**

- **Улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байна:** Улсын үзлэг, тооллогын ажлыг 2022 оны турш зохион байгуулж, улсын төсөвт тусгагдсан 300.3 сая төгрөгийн санхүүжилтийг тоног төхөөрөмж, программ хангамж, түүний зөвшөөрөл, томилолтын зардал, хэвлэлийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан;
- Улсын үзлэг тооллогод нийт төрийн болон орон нутгийн өмчийн 6613 хуулийн этгээдийг хамруулж, 91.7 их наяд төгрөгийн хөрөнгө тоологдлоо;
- Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллогын нэгдсэн дүнг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгосон.

Гурав. Дүгнэлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, дээд шатны байгууллагад өргөн баригдсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийд батлагдаагүй ч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох журам, дүрэм, аргачлалыг боловсруулан мөрдүүлж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлын дүн мэдээг хянан баталгаажуулах ажил бүрэн хийгдэж дуусаж Засгийн газрын хуралдаанд танилцуулахад бэлэн болсон байна.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал /Зөвлөмж/

- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарсан санхүүжилтийг өссөн дүнгээр тодорхой тайлagnаж байх;


Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Н.ГАНБОЛД

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
МЭРГЭЖИЛТЭН  Д.ЦЭРЭНЛХАМ